



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
МАТЕРИАЛ**

---

2015.04.30

*Хурлын материалын агуулга:*

- 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол*
- 2. Хурлын дэг*
- 3. Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт*
- 4. Саналын хуудас*
- 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл*
- 6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт*
- 7. Компанийн товч танилцуулга*
- 8. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан*
- 9. Силикат ХХК-ийн дүрэм*
- 10. Силикат ХК-ийг Силикат ХХК болгон өөрчлөн зохион байгуулах төсөл*
- 11. Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын хийсэн үнэлгээний тайлан дүгнэлтийг харгалзан нэгж хувьцааны үнийг тогтоох нь*
- 12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх хувьцааны үнийн талаарх санал*
- 13. Хөрөнгийн үнэлгээ*
- 14. Бизнесийн үнэлгээ*
- 15. “Силикат”ХК-ийг өөрчлөн байгуулагдсантай холбогдон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам*
- 16. Хувьцаатай холбогдолтой нэмэлт материалууд*
- 17. Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг компаниас эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлт*
- 18. Хувьцаа эзэмшигч нь шаардах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаж хаалттай компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт*

"СИЛИКАТ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ.

Монгол улс, Дархан хот, Үйлдвэрийн дүрэг, "Силикат" ХК, ШХ-964, Утас 99990095.

2015.03.18

№ 01

Дархан-Уул аймаг.

Силикат ХК-ийн ТУЗ-н шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай

ТОГТООЛ

1. Компанийн 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Силикат ХК-ийн байранд 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цагт зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
  - Компанийн хэлбэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох, компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийг тогтоох зэрэг асуудлыг тус тус авч хэлэлцэн шийдвэрлэх
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 сарын 30-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-д мэдэгдэх өдрийг 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдөр, 4 дүгээр сарын 05-ны өдрүүд байхаар тогтоож Н.Цогцлонд даалгасугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 3 дугаар сарын 20-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсанд байршуулах, мөн 3 сарын 31-ний өдрөөс хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 3 сарын 20, 4 сарын 05-ний өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай. 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг 2015 оны 04 дүгээр сарын 03-ний өдрөөс 2015 оны 04 дүгээр сарын 10-ны дотор Силикат ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.



8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
9. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
10. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 12 цагаар тогтоосугай
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Н.Цогцлон гишүүдээр Д.Энхболд , В.Мөнхтуяа нарыг тус тус томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Ц.Сэргэлэнг тооллогын комиссын даргаар Д.Уранчимэг, комиссын гишүүдээр Р.Энхгэрэл, В.Мөнхцэцэг нарыг тус тус томилсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



Ц.Содбилэг

Ц.Сэргэлэн

Н.Цогцлон


Д.Энхболд

В.Мөнхтуяа

Н.Болормаа

М.Наранзул

Б.Сэр-Од




Силикат" ХК-ийн ТУЗөвөлөлийн 2015 оны 03  
дугаар сарын 18-ний өдрийн 01 дүгээр  
тогтоолын "Хавсралт-1"

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг.

- |     |   |           |
|-----|---|-----------|
| 1.  | Хурлын ирцийг бүртгэх ажлын хэсэг/ажлын хэсэг/  |           |
| 2.  | Хурлын ирцийг мэдээлэх/ажлын хэсэг  | 5 минут.  |
| 3.  | Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд<br>болон хурлын дэгийг танилцуулах.  | 5 минут.  |
| 4.  | Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах.   | 10 минут. |
| 5.  | Силикат ХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Содбилэг   |           |
|     | а. Компанийн санхүү, үйл ажиллагааны өнөөгийн байдал танилцуулах  |           |
|     | б. Компанийн хэлбэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох, компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийг тогтоох зэрэг асуудлыг тус тус авч хэлэлцэн шийдвэрлэх | 20 минут. |
| 6.  | Хувьцаа эзэмшигчид үг хэлэх, санал гаргах   | 20 минут. |
| 7.  | Санал хураалт.  | 20 минут. |
| 8.  | Хурлын завсарлага   | 5 минут.  |
| 9.  | Тооллогын комиссын дарга санал хураалтын дүнг танилцуулах.  | 15 минут. |
| 10. | Хурлаас гаргах шийдвэр, тогтоолын төслийг уншиж танилцуулах   | 10 минут. |
| 11. | Хурлыг хаах /хурлын дарга/  | 5 минут.  |

12



"Силикат" ХК-ийн ТҮЗөвлөлийн 2015 оны  
03 дугаар сарын 18- ний өдрийн 01 дүгээр  
тогтоолын "Хавсралт-2"

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт.

1. Компанийн санхүү/товч/,бизнесийн үйл ажиллагааны талаархи товч тайлан.
2. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл, компанийг ХХК болгон өөрчлөн байуулах төсөл
3. ХХК компанийн дүрмийн төсөл
4. Нэмж гаргасан үнэт цаасны арилжааны хэлцлийг хүчингүй болгуулахаар гаргасан маргааны талаархи материалууд.



"Силикат" ХК-ийн ТУ Зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолын "Хавсралт-3"

**“СИЛИКАТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС №.....**

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо .....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани / .....

Брокерийн овог ..... нэр .....

“Силикат” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цагт Силикат ХК-ийн байранд болно.

	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.				
2.	Хувьцаат компанийн хэлбэрийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах тухай!				
3.	Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.40₮-өөр шинэчлэн тогтоох тухай.				
4.	Хэлэлцэх асуудлаар ажлын комисс гаргах.				

Брокер ..... Гарын үсэг  
/ тэмдэг /

Хувьцаа эзэмшигч ..... Гарын үсэг

2015 оны..... сар.....өдөр

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч Брокерийн пүүсийн ажилтнууд бөглөн тамга даран баталгаажуулж, хувьцаа эзэмшигчид өгнө.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог, нэр, хаягийг дор нь бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, итгэмжлэл, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болон даалгаврын гэрээний хамт өгч явуулна.

Таны төлөөлөх хүний овог ..... нэр .....

Оршин байгаа газрын хаяг .....

.....

.....

5. Хувьцаа эзэмшигчийн хурлын талаар 99990095, 95271435 дугаарын утсаар лавлаж болно.
6. Санал авах хуудсыг хүчингүй болгосон тухай шалгтаан

.....

.....

.....



44

"Силикат" ХК-ийн ТУЗөвлөлийн 2015 оны  
03 дугаар сарын 18-ний өдрийн 01 дүгээр  
тогтоолын "Хавсралт-1"

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ.**

Компанийн нэр: Силикат ХК

Хаяг: Дархан Уул аймаг, Дархан сум, 13-р баг, үйлдвэрийн дүүрэг Силикат ХК-ийн хурлын танхимд болно.

Утас: 99990095 , 99053180

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2015 оны 04 сарын 30-ны өдрийн 14 цагт Силикат ХК-ийн байранд болно.

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо ТУЗ-ийн 2015 оны 03 сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоол

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн хэлбэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох, компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийг тогтоох зэрэг асуудлыг тус тус авч хэлэлцэн шийдвэрлэх

Хурлын тогтоолтой 2015 оны 04 дүгээр сарын 05-ын өдрөөс 2015 оны 04 дүгээр сарын 10 хугацаанд "Силикат" ХК-ийн байранд ирж танилцана уу.

Олон нийтэд зарласан огноо 2015 оны 03 сарын 20-ны өдөр

Бүртгэх өдөр 2015 оны 03 сарын 30-ны өдөр

Хүргүүлсэн огноо 2015 оны 03 сарын 19-ны өдөр

Хурал зохион байгуулах

комиссын дарга Н.Цогцлон /

2015 оны 03 сарын 19-ний өдөр.

“СИЛИКАТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Силикат” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цагт тус компанийн хурлын танхимд болно.

**Хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн хэлбэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох, компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийг тогтоох зэрэг асуудлыг тус тус авч хэлэлцэн шийдвэрлэх

**Бүртгэлийн өдөр:** 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

Хувьцаа эзэмшигч та бүхэн 2015 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2015 оны 04 дүгээр сарын 10-ны хооронд Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон санал авах хуудастай “Силикат” ХК-ийн байранд ирж танилцана уу.

Харилцах утас: 99990095, 99053180

E-mail хаяг: [gerel0321@yahoo.com](mailto:gerel0321@yahoo.com)

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС





МОНГОЛ УЛСЫН БАШТУУХЫН ЯРИЛГАА  
2012 он 02-р сар 28-ны өдөр баталсан



# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006.10.13  
/Бүртгэсэн он, сар, өдөр/

1910010007  
/Улсын бүртгэлийн дугаар/


2050463  
/Регистрийн дугаар/

Силикат Хувьцаат компани

\_\_\_\_\_ /Хуулийн этгээдийн нэр, харуулганы хэлбэр/

Дүрэм  
/Үүсэн байгуулах баримт бичиг/

тогтоол  
/Шийдвэрийн нэр/




1996.08.31  
он, сар, өдөр

269300  
код

Силикат тоосго, шохой үйлдвэрлэх  
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

519000



код

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй  
хугацаа

25


/Гишүүдийн тоо

17,012.6

/Өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөө

Дархан-Уул, Дархан сум, 15-р баг, Үйлдвэрийн район - өөрийн байр, утас:199113641, утас:2:96370052, факс:

\_\_\_\_\_ /Хуулийн этгээдийн албан ёсны хаяг/



Дархан-Уул аймгийн татварын хэлтэс  
/Бүртгэсэн байгууллагын нэр/



Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн	
			Огноо	Ажилтан, тэмдэг
ХХБ Дархан салбар	Валютын	403104383	2009.05.25	Б.Хүдэрбаяр
ХХБ Дархан салбар	Төвөргийн	403002943	2008.10.13	Б.Уранчимэг
Зоос банкны Дархан салбар	Төвөргийн	2402121572	2007.04.06	Б.Уранчимэг

Үүлийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтний бүрт


Дүд	Нэмэлт, өөрчлөлтний агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэг
	Энэ хуулийн этгээдэд 2008.10.13 өдөр олгосон гэрчилгээг хүчингүйд тооцож, гэрчилгээг дахин олгосон болно.	2010.01.14	А.Долгоржээ

Эндхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу кариуцлага хүлээлгэнэ.  
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



### Компанийн танилцуулага

Силикат ХК нь анх 1966 онд цагаан тоосго болон шохой үйлдвэрлэх зориулалтаар байгуулагдсан ба Монгол Улсын өмч хувьчлалын комиссын 1992 оны 40-р тогтоолоор хувьчлагдан Силикат ХК болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан. 2006 онд Силикат тоосгоны шугамыг MNS 831-2001 стандартын хөнгөн бетонд шилжүүлж, хөнгөн бетоны үйлдвэрийг ашиглалтанд оруулсан. Улмаар 2008 онд шохойн үйлдвэрт технологийн шинэчлэлт хийж MNS-347-2000 MNS-347-99 стандартуудыг хангасан шохой үйлдвэрлэсэнээр өөрсдийн хөнгөн бетоны хэрэгцээг хангаад зогсохгүй, боловсруулсан шохой нь барилгын материал үйлдвэрлэлийн гол түүхий эд төдийгүй ураны болон өнгөт металл боловсруулах үйлдвэр, алтны уурхайнуудад баяжуулалтын гол түүхий эд болдгоороо стратегийн чухал ач холбогдолтой түүхий эд юм. Манай байгууллага нь Дарханы Дулааны Цахилгаан Станцын уураар хөнгөн бетоноо 25 ата даралтаар 8 цаг жигнэж болгодог ба 4 автоклавтай. Станцын өндөр даралтын уур нь хэлбэлзэл байхгүй учир бүтээгдэхүүн түүхийрэх асуудал байхгүй, бат бэх өндөртэй блок гардаг. Силикат ХК нь одоогоор 80 гаруй ажилчин ажиллагсадтайгаар хөнгөн бетон блок, шохой үйлдвэрлэл, шохойн чулууны олборлолт гэсэн үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Хоногт 132 м3 хөнгөн бетон 20 тн боловсруулсан шохой үйлдвэрлэж байна. Силикат ХК-ийн үйлдвэр нь Дархан уул аймгийн үйлдвэрийн районд өөрийн салаа төмөр зам, авто зам, шохойн чулууны орд, элсний орд зэрэг дэд бүтэц бүхий үйлдвэрийн барилга байгууламж, талбайг ашиглан үйлдвэрлэлээ явуулж байна.





ДАРХАН УУЛ АЙМАГ ДАРХАН СУМ "СИЛИКАТ" ХК-ИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2014 оны жилийн тайлан тэнцлийн хураангуй үзүүлэлт

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ӨРӨНГӨ</b>			<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			<b>Богино хугацаат өр</b>		
Мөнгө түүнтэй адилтгах	3,575,112,543.57	868,223.51	Богино хугацаат өр	5,548,664,460.53	1,706,887,497.91
Дансны авлага	444,505,112.84	296,275,524.28	<b>Урт хугацаат өр</b>		
Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00	Урт хугацаат зээл	0.00	0.00
Бусад авлага	0.00	0.00	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
Бусад санхүүгийн	0.00	0.00	Хойшлогдсон	0.00	0.00
Бараа материал	1,401,555,512.36	1,339,570,661.37	Бусад урт хугацаат	0.00	0.00
Урьдчилж төлсөн зардал	0.00	0.00	<b>Урт хугацаат өр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00	<b>Өр төлбөрийн нийт</b>	<b>5,548,664,460.53</b>	<b>1,706,887,497.91</b>
Борлуулах зорилгоор эмшиж буй эргэлтийн бус	0.00	0.00	Эздийн өмч		
<b>Эргэлтийн хөрөнгийн</b>	<b>5,421,173,168.77</b>	<b>1,636,714,409.16</b>	Төрийн өмч	0.00	0.00
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			Хувийн өмч	17,012,600.00	17,012,600.00
Үндсэн хөрөнгө	3,890,615,655.73	659,773,949.21	Хувьцаат өр	0.00	0.00
Биет бус хөрөнгө	83,266,502.03	81,238,055.28	Халаасны хувьцаа	0.00	0.00
Биологийн хөрөнгө	0.00	0.00	Нэмж төлөгдсөн	0.00	0.00
Урт хугацаат хөрөнгө	0.00	0.00	Хөрөнгийн дахин	3,595,287,761.33	430,305,127.50
Хайгуул ба үнэлгээний	0.00	0.00	Гадаад валютын	0.00	0.00
Хойшлогдсон татварын	0.00	0.00	Эздийн өмчийн	0.00	0.00
Хөрөнгө орлуулалтын	0.00	0.00	Хуримтлагдсан	234,090,504.67	223,521,188.24
Бусад эргэлтийн бус	0.00	0.00	Эздийн өмчийн дүн	3,846,390,866.00	670,838,915.74
<b>Эргэлтийн бус хөрөнгийн</b>	<b>3,973,882,157.76</b>	<b>741,012,004.49</b>			
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН</b>	<b>9,395,055,326.53</b>	<b>2,377,726,413.65</b>	<b>НИЙТ</b>	<b>9,395,055,326.53</b>	<b>2,377,726,413.65</b>

Үзүүлэлт	2014 он
1.Цэвэр борлуулалт	903 123 810.29
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	792 834 953.65
3. Үйл ажиллагааны зардал	120 798 173.07
4.Ашиг	-10569316.43
5.Хувьцааны дундаж ханш	
6.Хувь нийлүүлэгчдийн тоо	
7. Хувьцааны төвлөрөлийн хувь	

ДАРХАН УУЛ АЙМАГ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *С.З.Д.* СОДБИЛЭГ  
СИЛИКАТ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ *Д.УРАНЧИМЭГ*  
БСМ00144 2020463



**“СИЛИКАТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРИЙГ  
ӨӨРЧИЛЖ “СИЛИКАТ” ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГТАЙ КОМПАНИ БОЛГОХ ТӨСӨЛ.**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.**

1.1. Энэхүү төсөл нь “Силикат” Хувьцаат Компани /ХК/-ийг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 1 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Компанийн дүрэмд заасны дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гаргах, өөрчлөн байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, өөрчлөн байгуулсантай холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх, компанийн хувьцааг Санхүүгийн Зохицуулах Хорооны бүртгэл болон Монголын Хөрөнгийн Биржийн жагсаалтаас хасуулах, компанийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдсон ажиллагааг зохицуулахад чиглэгдэнэ.

**ХОЁР. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨХ ШАЛТГААН, ЗОРИЛГО**

2.1. “Силикат” ХК нь анх 1966 онд “Цагаан тоосго. Шохойн фабрик” нэртэйгээр байгуулагдсан Өмч хувьчлалын комиссын 1992 оны 40-р тогтоолоор бүрэн хувьчлагдаж, нээлттэй хувьцаат компани болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан. Компани нь нийт 4 га талбайтай. Компани нь Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн дүүрэгт, өөрийн байранд үйл ажиллагаа явуулдаг.

Хувьчлагдсанаас хойш уламжлалт бизнес болох хөнгөн бетон блок, шохойн үйлдвэрлэлийг эрхэлж ирсэн.

Цаашид үйл ажиллагаагаа төрөлжүүлэн эрхэлнэ. Одоогоор тус компани нь нийт 143 хувьцаа эзэмшигчтэй, 46 334 602 ширхэг хувьцаатай бөгөөд үүний 99,17 хувийг буюу 45 945 228 ширхэг нь 7 хүний мэдэлд төвлөрсөн бөгөөд эдгээр нь нэгдмэл сонирхолтой этгээдүүд болно.

2.2. Дээрхи үлдэгдэл буюу олон нийт эзэмшдэг 0.83%-ийн хувьцааг эзэмшигч 135 иргэдийн хувьд өнөөг хүртэл хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцдоггүй, ногдол ашгаа авдаггүйгээс гадна ҮЦТГТХТ дахь үнэт цаасны дансаа ч идэвхжүүлээгүй зэрэг, өөрсдийн хуулиар олгогдсон эрх үүргээ ямар ч хэлбэрээр хэрэгжүүлэхгүй байна.

2.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт хувьцааны 99,17 хувь нь төвлөрсөн болон энэхүү төслийн 2.2-д дурдсан шалтгааны улмаас одоогийн бүтцийг өөрчилж ХХК болгон, идэвхтэй, санаачлагатай хувь нийлүүлэгчдийн цомхон бүрэлдэхүүнтэйгээр ирээдүйн үйл ажиллагаа, цаашдын чиг хандлагаа тодорхойлон ажиллах нь илүү үр дүнтэй гэж үзсэн болно.

**ГУРАВ. ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, НӨХЦӨЛ**

3.1. Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 18, 23 дүгээр зүйлд заасны дагуу ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр ХХК болон өөрчлөгдөж болох талаар заасан нь компанийг өөрчлөх эрх зүйн үндэслэл болно.

3.2. Компанийн нийт саналын эрхтэй хувьцааны 99,17 хувь нь нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн өмчлөлд төвлөрсөн, тэдгээр нь компанийг ХХК болгох замаар өөрчлөн зохион байгуулах, хуваах асуудлаар санал нэгтэй байгаа нь компанийг өөрчлөх шийдвэрийг хуульд нийцүүлж гаргах нөхцөл бүрдэнэ.



#### **ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ**

- 4.1. Компанийн тухай хуулийн 60, 62 дугаар зүйл, компанийн дүрмэнд заасныг үндэслэл болгон компанийг өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 14:00 цагаас компанийн байранд хуралдуулна. Хурлын талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, хурлын бичиг баримт бэлтгэж тараах, хурлыг хуралдуулж, шийдвэр гаргуулах болон бусад ажиллагааг Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон холбогдох хууль журамд нийцүүлэн явуулах үүргийг Төлөөлөн Удирдах зөвлөлөөс томилогдсон компанийн хэлбэрийг өөрчлөх комисс / цаашид комисс гэх/ хэрэгжүүлнэ.
- 4.2. Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 4.3. Компанийн тухай хуулийн 23.2, 63.7-д заасны дагуу хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ

#### **ТАВ. ХУВЬЦААГ ХӨРВҮҮЛЭХ АРГА, ТООЦОО**

- 5.1. “Силикат” ХК-ийн нэгж хувьцаа бүр өөрчлөн байгуулагдах “Силикат” ХХК-ийн нэгж хувь болон хөрвөнө.
- 5.2. Өөрчлөн байгуулагдах “Силикат” ХХК-ийн нийт хувьцааны тоо нь хувьцаа эзэмшигч хэвээр үлдэхээр санал гаргасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

#### **ЗУРГАА. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХЫН ЭСРЭГ САНАЛТАЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

- 6.1. Компанийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч компанийг өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй байна.
- 6.2. Эргүүлэн худалдаж авахаар тохиролцсон компанийн хувьцаа нь өөрчлөн байгуулагдах компанийн хувьцаанд хөрвөх боломжгүй байна.
- 6.3. Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс хөндлөнгий мэргэжлийн байгууллагын хийсэн үнэлгээний тайлан, дүгнэлтийг харгалзан тогтоож, ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулсан байна.
- 6.4. Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсгэсэн шийдвэр гарах тохиолдолд энэ эрх, түүнийг хэрэгжүүлэх журмын талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ.
- 6.5. Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах бол хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсанаас хойш ажлын 30 хоногийн дотор компанид бичгээр ирүүлсэн байна.
- 6.6. Компани эргүүлэн худалдаж авахыг шаардсан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн зарласан үнээр худалдаж авах, эсхүл тэдгээрийг худалдаж авахаас татгалзсан үндэслэлээ хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 6.7. Хэрэв компани эргүүлэн худалдаж авахаар мэдэгдсэн бол хувьцааны үнийг ҮЦТТХТөвтэй гэрээ байгуулж болно.

**ДОЛОО. ӨӨРЧЛӨН БАЙГУУЛЖ ДУУСАХ.**

- 7.1. Өөрчлөн байгуулахтай холбогдон энэ төслийн 4, 5, 6 дугаар хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж дууссаны дараа комисс тайлангаа гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-нд хүргүүлэн хувьцаагаа бүртгэлээс хасуулах арга хэмжээ авна.
- 7.2. СЗХ-оос хувьцааг бүртгэлээс хасах тухай шийдвэр гарсан үед Монголын хөрөнгийн биржийн жагсаалт болон “ҮЦТТТХТөв” ХХК-ийн бүртгэлээс хасуулах арга хэмжээ авна.
- 7.3. Өөрчлөн байгуулагдсан “Силикат” ХХК-д хувьцаа эзэмшигч хэвээр үлдсэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, анхдугаар хурлын тэмдэглэл, компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүргүүлж, улсын бүртгэлд бүртгүүлснээр компанийг өөрчлөн байгуулж дууссанд тооцно

**“СИЛИКАТ” ХУВЬЦААТ КОМПАНИ.**



## ХӨНДЛӨНГИЙН МЭРГЭЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ДҮГНЭЛТИЙГ ХАРГАЛЗАН ХУВЬЦААНЫ ШИНЭЧИЛСЭН ҮНЭ ТОГТООХ НЬ

2011 онд нэмэлт хувьцааг хөрөнгийн зах зээлд санал болгох анхны үнийг 225 төгрөгөөр тогтоосон боловч улс орны эдийн засагт хямралтай байдал бий болсон. Шохойн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжих бололцоогүй болсон, компанийн орлого буурсан зэрэг шалтгааны улмаас хувьцааны үнийг үнэт цаасны хууль тогтоомж, хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээний байгууллагын хийсэн үнэлгээний тайлан дүгнэлтийг харгалзан

Дараах 3 аргаар тооцож үзэхэд

- 1.Хөрөнгийн хандлагаар
- 2.Орлогын хандлагаар
- 3.Зах зээлийн хандлагаар

Компанийн борлуулалтын орлого жил бүр буурч байгаа учраас хувьцааны үнийг тогтооход орлогын арга нь бодит үнэлгээ болж чадахгүй гэж үзсэн.

Хувьцааны арилжааны сүүлийн 6 сарын дундаж ханш нь 220 төгрөг байгаа ба нийт хувьцааны 99.17 хувь нь нэгдмэл сонирхолтой этгээдэд төвлөрсөний улмаас зах зээлийн зарчмаар үнэ тогтоогдох боломжгүй юм.Иймд энэ аргад ач холбогдол өгөх шаардлагагүй гэж үзсэн.

Хөрөнгийн аргаар тооцохдоо Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Хөндлөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага “ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ ХХК”-ийн хийсэн үнэлгээн дээр тулгуурлалаа.

$$P_0 = \frac{BY}{X_{\text{тоо}}} = \frac{3,679,364,900}{46,334,602} = 79.40 \text{ төг}$$

P<sub>0</sub>- Өнөөгийн үнэ цэнэ/зах зээлийн үнэ/

BY- Бизнесийн үнэлгээ

X<sub>тоо</sub>- Хувьцааны тоо

Нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь 79.40 төгрөг болж байна.

Иймд 2015 оны 04 сарын 30-ны өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.40 төгрөгөөр тогтоох санал оруулахаар шийдвэрлээд байна.

**СИЛИКАТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

### ХУВЬЦААНЫ ҮНИЙН ТАЛААРХ САНАЛ.

2015 оны 4-р сарын 30.

“Силикат”ХК нь 1966 онд байгуулагдан, 1996 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болж 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 100 төгрөгөөр тогтоосон.

Тус компани 2010-2011 онд жилдээ 3,6 тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг байсан бөгөөд 2011 онд Шохойн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлснээр жилдээ 7,7 тэрбум төгрөгийн борлуулалт хийнэ гэж тооцон нэмж гаргах нэгж хувьцааны үнийг 225 төгрөгөөр тогтоосон.

СЗХорооны 130, 241 дүгээр тогтоол гарах үед “Силикат”ХК нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк/ЕСБХБ/-нд чанаргүй зээлийн муу гэх ангилалтай, 1.4 тэрбум төгрөгийн өртэй, компанийн бүх хөрөнгө, хувьцаа шүүхийн шийдвэрээр битүүмжлэгдсэн байсан.

2011 оны 02 сард ЕСБХБанк өөрийн төслийн зээлэнд хамрагдаж байсан компаниудад “төлбөр барагдуулах хөнгөлөлт үзүүлсэн”. Энэ хүрээнд “Силикат”ХК өр төлбөрийг 50 хувь хөнгөлүүлж 727 сая төгрөгөөр төлөхөөр “Зээлийн төлбөр барагдуулах 24 тоот гэрээ”-г байгуулсан.

Гэтэл СЗХороо нь “...Силикат компанийн бусдад төлөх 727 сая төгрөгийн өрийг 1.4 тэрбум төгрөгөөр төлөхийг ҮЦТТХТ-/Т.Гандуламд/-д үүрэг болгосон заалтыг 241-р тогтоолын 9.2-т заасан.

Үүний улмаас үнэт цаас гаргагч, СЗХороо, андеррайтер компанийн хооронд маргаан гарч, 2011 оноос 2014 он хүртэл 3 жилийн хугацаанд асуудлыг шийдвэрлүүлэхээр зургаан шатны шүүхээр маргасан.

Энэ хугацаанд тус компани жилд дөнгөж 900 сая төгрөгийн борлуулалт хийх болж, төлөвлөсөн орлого 10 дахин буурсан төдийгүй төсөлд зориулан худалдан авахаар төлөвлөсөн техник, тоног төхөөрөмжийн үнэ, гаалийн татвар, тээврийн зардал, бензин, шатах тослох материалын үнэ 2 дахин өссөнөөс Шохойн төсөл хэрэгжих бололцоогүй болсон.

Маргааны эцэст СЗХороо, андеррайтер компаниас манайд компанид гаргасан “олон нийтэд санал болгон худалдсан хувьцаагаа эргүүлэн худалдан авах” тухай саналыг бид хүлээн зөвшөөрч 2014 оны 04 сард хувьцаа эзэмшигчдийн хуралыг зарлан хуралдуулж 99,67 хувийн ирцтэй, 100 хувийн дэмжих саналаар нэмэлт хувьцааг эргүүлэн худалдан авах шийдвэр гарган хурлын материал, шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.



“Силикат”ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03 сарын 18-ны өдрийн хурлаас Хувьцаат компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх, нэгж хувьцааны үнийг тогтоох тухай компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04 сарын 30-ны өдөр хуралдуулах тухай шийдвэр гаргалаа.

“Шохойн төсөл” хэрэгжсэнээр жилд 7.7 тэрбум төгрөгийн орлого олно гэж тооцон нэгж хувьцааны анхны үнийг 225 төгрөгөөр тогтоосон.

Гэвч өнгөрсөн хугацаанд жилд 900 сая төгрөгийн борлуулалт хийх болсон бөгөөд компанийн нийт хувьцааны үнийг орлогын үнэлгээний аргаар тооцон үзэхэд нэгж хувьцааны зах зээлийн өнөөгийн бодит үнэ 26.55 төгрөг болж байна.

Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бизнес зөвлөх үйлчилгээний “Итгэлт-Эстимейт”ХХК 2015 оны 04 сард манай компанийн хөрөнгийн үнэлгээг хийгээд тус компанийн нэгж хувьцааны үнийг хөрөнгийн үнэлгээний аргаар тооцоод, “Силикат”ХК-ийн нэгж хувьцааны зах зээлийн бодит үнэ 79,4 төгрөг болохыг тогтоосон.

Иймд 2015 оны 04 сарын 30-ны өдөр хуралдах “Силикат”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тус компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.4 төгрөгөөр тогтоохоор хэлэлцүүлэхээр санал оруулахаар шийдвэрлэв.

**“СИЛИКАТ”-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ.**

Нууц Мэдээлэл 2023  
Апр 12 2015  
"СИЛИКАТ" ХК  
Дархан, Монгол Улс

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн бодит үнэ тодорхойлох үнэлгээ

"ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК ("ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ", "Бид" эсвэл "бидний") нь "СИЛИКАТ" ХК-ийн (цаашид "Компани" гэх) 100%-ийн өмчлөлийн барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн зах зээлийн хэрэгслийн хандлага, Орлого кашигалжуулах арга, Зах зээлийн харьцуулалтын аргуудад үндэслэн 2015 оны 01 сарын 01-ний өдрөөр ("Үнэлгээний өдөр") тооцоолохоор сонгогдсон. "СИЛИКАТ" ХК-ийн бизнесийн үнэлгээг хөрөнгийн хандлагаар хийхэд ашиглах зориулалтаар хөрөнгийн үнэлгээг хийсэн. Үнэлгээний зорилгоор хийсэн шинжилгээ, судалгаанаас гарсан мэргэжлийн санал дүгнэлт, хэрэглэсэн аргачлал, горимуудын тайлбар болон дүгнэлтэд хүрэхэд авч үзсэн хүчин зүйлсний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан тайланд тусгасан. Үүнээс гадна бид тайланд хэрэглэсэн мэдээллийн эх сурвалжийн жагсаалт болон шинжилгээний явцад хийсэн ажлын цар хүрээг зохих хязгаарлалтын хамт оруулсан.

Бидний гүйцэтгэсэн үнэлгээний тооцоолоор "СИЛИКАТ" ХК-ийн үнэлгээнд хамрагдсан барилга, байгууламжийн 2015 оны 01-р сарын 01-ний байдлаархангиллын үнэ цэнэ нь 2,916,182.6 мянган (Хоёр тэрбум есөн зуун арван зургаан сая нэг зуун наян хоёр мянга зургаан зуун) төгрөг, машинтоног төхөөрөмжийн ангиллын үнэ цэнэ 664,544.3 мянган (Зургаан зуун жаран дөрвөн сая таван зуун дөрчин дөрвөн мянга гурван зуун) төгрөг, тээврийн хэрэгслийн ангиллын үнэ цэнэ нь 65,750.0 мянган (Жаран таван сая долоон зуун тавин мянган) төгрөг тус тус байх үндэслэлтэй байна.

Хүндэтгэсэн,




К.Эрэнбаяр Ерөнхий захирал  
"ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

  
В.Алтанпүрэв  
Ахлах үнэлгээчин



Э.Галбаатар  
Э Үнэлгээчин

Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчин / Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчин



57





# “ИТГЭЛТ-ЭСТИМЭЙТ” ХХК

Бизнес, үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

2015-04-20

№26/01

Улаанбаатар

## СИЛИКАТ ХК-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.СОДБИЛЭГ ТАНАА

### Үнэлгээний тайлан хүргүүлэх тухай


“Силикат” ХК-ийн бизнесийн үнэлгээг Олон Улсын Үнэлгээний Стандарт 1-ийг баримтлан хараат бусаар хийж, 2015 оны 01-р сарын 01-ний байдлаар **3,679,364,900** (гурван тэрбум зургаан зуун далан есөн сая гурван зуун жаран дөрвөн мянга есөн зуу)-н төгрөгөөр тогтоов.

Бид зохих журмын дагуу мэдээ, мэдээлэл цуглуулж, түүнийгээ шалгаж, боловсруулж, судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр үнэлгээний сонгодог гурван аргаар дүгнэлт гаргаж, тэдгээрийг жигнэж бизнесийн үнэлгээг хийлээ.

“Силикат” ХК-аас үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүгийн байдлын талаарх бүх шаардлагатай мэдээллийг бидэнд бэлтгэж өгсөн бөгөөд түүний үнэн зөв болохыг нотолсон баталгаа бичиг гаргуулж авсан.

### ГҮНЭЭ ХҮНДЭТГЭСЭН

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ө.ЭРДЭНЭБАЯР

Хаяг :БЗД, 14-р хороо Намянжүгийн гудамж 194/1 Борх төв 101, 102, 201 тоот.

Утас/факс: (976-11)455088; Гар утас: 99015638

Web site: [www.itgelt-unelgee.mn](http://www.itgelt-unelgee.mn) E-mail: [itgelt\\_estimate@magicnet.mn](mailto:itgelt_estimate@magicnet.mn)

**"СИЛИКАТ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ.**

**“СИЛИКАТ” ХК-ИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАГДСАНТАЙ**

**ХОЛБОГДОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**

**ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ.**

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг өөрчлөн байгуулах шийдвэр гарсан тохиолдолд Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигч нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах, эсхүл өөрчлөн байгуулагдсан компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх эрх үүснэ.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж, компанийг ХХК болгон өөрчлөн байгуулах шийдвэр гарсан үед Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг комисс зохион байгуулна.
3. Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүсгэх шийдвэр гарсанаар хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн болон худалдан авах хугацаа, журам, үнийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (өдөр тутмын 2-оос доошгүй сонин, радио болон телевиз)-ээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж, брокер, дилерийн компаниуд /БДК/-ад бичгээр мэдээлэл хүргүүлнэ.
4. Компанийн тухай хуулийн 54.3-т заасны дагуу олон нийтэд анх мэдээлсэн өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардлагыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хүлээн авна. СЗХ-ны 2014 оны 01 дугаар сарын 06 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”д заасны дагуу хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардсан хувьцаа эзэмшигч нь шаардлагадаа өөрийн овог нэр, оршин суугаа хаяг, эргүүлэн худалдахыг шаардаж байгаа хувьцааны тоо зэргийг заасан байна.
5. Хөдөө орон нутагт оршин суугаа хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардлагыг орон нутагт дахь брокер, дилерийн компаниудаар дамжуулан авч болно.
6. БДК нь иргэдийн хувьцааг худалдан авахдаа тэдгээрээс энэ журмын 4-т заасан шаардлага, тухайн хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар зэргийг заавал хавсаргасан байна
7. Өөрчлөн байгуулагдах “Силикат” ХХК-ийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг хүлээн авах хугацаа нь компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласнаас хойш хуанлийн 60 хоног байна. Компанийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх тухай хүсэлтээ энэ журамд заасны дагуу гаргасан тохиолдолд өөрчлөн байгуулагдах компанийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэнэ.



8. Хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх саналаа дараах бичиг баримтыг бүрдүүлж гаргана.

- Бичгээр гаргасан хүсэлт
- Иргэний үнэмлэхийн хуулбар /2 хувь/
- Хувьцаа эзэмшигч гэдгээ нотлох баримт
- ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр бүртгүүлэх анкет 2 хувь /УБЕГ-ын/

9. Өөрчлөн байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаанд Компанийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх хүсэлтээ гаргаагүй хувьцаа эзэмшигчдийг татгалзсанд тооцож, хувьцааны үнийг “ҮЦТТТХТ” ХХК-д шилжүүлж мөнгийг хувьцаа эзэмшигчдэд олгоно. Ингэхдээ ХК-ийн хэлбэрийг өөрчилж ХХК болгох төслийн 6.5, 6.6-д заасан хугацаа өнгөрмөгц хувьцаа эзэмш хэвээр үлдэхээр саналаа гаргасан хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг ҮЦТТТХТөвд мэдэгдэж, хувьцаа эзэмшигч хэвээр үлдэхээс татгалзсан хувьцаа эзэмшигчдэд олгох хувьцааны үнийг шилжүүлнэ.

10. ХК-ийн хэлбэрийг өөрчилж ХХК болгох төслийн 6.5, 6.6-д заасан хугацаа өнгөрмөгц өөрчлөн байгуулагдах “Силикат” ХХК-тай компанийн анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна.

**"СИЛИКАТ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ.**



...урхан хөлдүү туулд...  
 тахилга үйлдэж байх үеэр  
 Өвөрмонгол, Хятад, Монгол  
 залуустай таарсан юм. Тэгээд  
 тэнд байсан монгол залуус  
 хятадуудыг сөгдүүлсэн байхад  
 нь учирлаж, салгаж явуулсан  
 юм. Гэтэл биднийг ийм үйлдэл  
 хийлээ хэмээн цахим сүлжээнд  
 тавьж байгаад харамсч  
 байна. Энэ нь бидэнд сөргөөр  
 туслаа. Энэ бол Ар Монгол,  
 Өвөр Монголын найрамдал  
 харилцааны асуудал юм. Иргэд  
 ч буруу ойлголттой үлдлээ. Бид  
 үүнд л их бухимдаж байна.  
 Ялангуяа 14-15 насны өсвөр  
 үеийн залуус эсрэг бодолтой  
 байгаад их харамсч байна.  
 Яруу найрагч О.Дашбалбар  
 гуай хэлсэн байдаг шүү дээ  
 биднийг буруутгах тусам бид  
 дээшээ тэмүүлэх болно. Мөн  
 биднийг буруутгаад байгаа  
 хүмүүстэй хэлз тулахыг хүсч  
 байна" гэсэн юм.

**МДОЛ ГАРГААГҮЙ Ч  
 АЛГАНА**

учруулав танхайрсан байна уу,  
 иргэний эрх чөлөөнд халдсан  
 уу гэдгийг шалгаж тогтоогоод  
 ямар зүйл ангид хамруулах  
 вэ гэдгийг гаргана.

Монгол Улсад мөрдөж  
 байгаа хуулиар гадаадын  
 ч бай, дотоодын ч бай  
 иргэний эрхийг зөрчсөн  
 бол хариуцлага хүлээлгэдэг.  
 Гадаадын иргэний эрхийг  
 зөрчсөн учраас цагдаагийн  
 байгууллага тоохгүй байна  
 гэж ойлгож болохгүй.

**-Босоо хөх монгол  
 хөдөлгөөнийхөнтэй уулзсан  
 уу. Ямар тайлбар хэлж  
 ё та вэ?**

-Фэйсбүүкт хуудастаа  
 тавьсан шиг л ярьж байгаа.  
 Иргэн өөрөө ямар нэгэн  
 шаардлага тавьж бусдын эрх  
 чөлөөнд халдах нь хуулиар  
 хориотой байдаг.

Борлуулалтын хэмжээ: 2013, 2014 онуудын борлуулалтын дундаж орлого 450,000,000 сая /дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: 450,000,000 төгрөг. /Дөрвөн зуун тавин сая/

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2013, 2014 он.

Ижил төстэй ажлын өртөг: 2012, 2013, 2014 онуудын аль нэг жилд 450,000,000 /Дөрвөн зуун тавин сая/ төгрөгөөс багагүй далан суваг, гедротехникийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэсэн байх

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Барилга хот байгуулалтын яамны 2.3.2 Херсний ус доошлуулах, шүүрүүлэх, эргийн бэхлэгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан,хоолой болон газар шорооны тусгай ажил.

Тендерийн хамт 15,000,000 /арван таван сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: Оролцох эрхгүй

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцох эсэх: Тооцно.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар авч болно.

УБ хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,  
 Нийслэлийн Засаг захиргааны IV байр, Нийслэлийн Худалдан авах  
 ажиллагааны газар,  
 10 давхарт, мэргэжилтэн Б.Бат-Орших

Холбоо барих утасны дугаар: 75757805

**"СИЛИКАТ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

"Силикат" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдрийн 15.00 цагт Дархан-Уул аймаг, Дархан сум, 13 дугаар баг, Үйлдвэрийн дүүрэг, Силикат-ХК-ийн өөрийн байранд хурлын танхимд хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2015 оны гуравдугаар сарын 30-ны өдөр.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
  2. Компанийг ХХК болгон өөрчлөн байгуулах төсөл
  3. Өөрчлөн байгуулагдсантай холбогдон компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журмын төсөл
  4. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн мэдээлэл
  5. Өөрчлөлтөөр бий болох ХХК-ийн дүрмийн төсөл
  6. Өөрчлөлтөөр бий болох ХХК-ийн ТУЗ-ийг сонгох
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК-иар дамжуулан болон компанийн байранд ажлын өдрүүдэд (Даваа-Баасан) 9:00 цагаас 18:00 цаг хүртэл авах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдтэй холбоо барих,  
 мэдээлэл авах утас: Н.Цогцлон, Утас 99119539

Е-мэйл хаяг: gerel032100@gmail.com  
 "СИЛИКАТ" ХК-ИЙН ТУЗ

ӨДӨРТ 35 БОЛОН АЖИЛЛАГААНЫ ӨДӨР

www.ASSA.mn

ШУУРХАЙ УЕЛСЭЛТИЙН УУДАСНЫ ӨДӨР

- ✓ СПОРТ
- ✓ СОЁЛ УРЛАГ
- ✓ ЭНТЕРТАЙНМЕНТ
- ✓ ФОТО
- ✓ ЦАР МЭДЭЭ
- ✓ ТЕНДЭР



агентлаг редактор, Гадаадын иргэн харьяатын газарт хэвлэлийн төлөөлөгчөөр ажиллах зуураа дээр нэр дурдсан номоос гадна "Бурхан нуусан нүд" түүвэр, "Гэгээн сонор" дуу, шүлгийн цомог гаргасан Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагч юм. Тэр "Мөнх тэнгэрийн хүчин дор" киноны Чингэс хааны дүрээр олны танил болсон гавьяат жүжигчин А.Энхтайвантай "Санасан шүү, чамайгаа" дуу зохиож, "Явлаа гэж чанга битгий хэлээрэй", хөгжмийн зохиолч Чинбаттай "Уучил", гавьяат жүжигчин С.Жавхлангийн "Эвийн хоёр хайр" зэрэг олон сайхан дууны шүлгийг зохиосон авьяасын гэрэлт найрагч юм. Намуун уянгын гэрэлт найрагч Байгалаа эгч маань эцэс Дорноговь аймгийн номын сангийн эрхлэгчийн алба хашиж буй. Түүний "Эр хүн чинь уйлдаггүй юм аа, элгэн хад нурдаг юм аа" гэдэг шүлгийг манай хөвгүүд мөн ч олон удаа хамтран уншиж явсан даа.

Манай ангийн С.Оюун Бакула Ренбүүчийн хийдэд, Б.Оюунбилэг Баянхошууны хийдэд тус тус буяны үйл эрхэлж, Д.Энхсайхан гэж Завхан нутгийн охин Улсын цаг уурын хүрээлэнд нягтлангаар ажиллаж байгаа. Л.Энхмаа, Ш.Отгонбаяр, Б.Дулмаа нар ерөнхий боловсролын сургуульд түмний хүүхдэд эрдмийн гэгээ түгээж, Ц.Отгонтуяа, Н.Батжаргал нар х араа хөдөлмөр эрхэлж, Д.Тамхайдорж, Н.Хандсүрэн, И.Уранчимэг нар хилийн чинадад ажиллаж амьдарч байна. Манай ангид МЗЭ-ийн шагналт яруу найрагч Ц.Доржсэмбэ, сэтгүүлч Г.Машбат болон яруу найрагч Р.Эмүжиний ах Р.Соёлсайхан нар нэгэн үе суралцаж байсан. Ерэн найман оны хоёрдугаар сард хонхны баяраа хийхэд О.Дашбалбар багш маань Зуун айл дахь гэрт маань гэнхэр гитартайгаа ирж, ангийхан маань шөнежин дуулж хуурдаж байсан тэр л гэгээн дурсамж өнөө ч сэтгэл зүрхэнд дотныхон байна.

Л.БАТЦЭНГЭЛ



Испанийн уран зургийн томоохон төлөөлөгчдийн нэг Диего Родриго де Велазкез Севиль хотноо төржээ. Төрсөн он нь тодорхойгүй бөгөөд анх 1610-1611 оны орчим нэрт зураач Пачечогийн урланд суралцаж байсан гэсэн мэдээ тэмдэглэгдэн үлджээ. 1617 онд албан ёсоор ахлах буюу мастер-зураач болон өргөмжлөгдсөн бөгөөд жил орчмын дараа багш Пачечогийнхоо охинтой гэрлэсэн байна. Тэрээр хадам аавынхаа уран бүтээлийн арга барилыг өвлөн авч баяжуулан өөрийнхөө өнгө аяс, барилыг бий болгожээ. Алдарт зураач Рубенсийг 1628-1629 онд Испанид ирэхэд нь танилцан нөхөрлөсөн гэдэг. 1630-1640 он Велазкезийн уран бүтээлийн хамгийн оргил үе байсан бөгөөд Велазкез "Тольдож буй Венера" зургаа 1648 онд зурж дууссан байна. "Тольдож буй Венера"

зураг нь Тициан "Урбины Венера"-гийн адил өргөн дэлгэр сурталчлагдсан. Венераг хамгийн гоолиг сайхнаар дүрслэн үзүүлсэн зурагнуудын нэг юм. Энэхүү зургийн ид шид уран байдлыг үгээр дүрслэн хэлэхэд ч хэцүү. Гайхалтай тод улаан, зөөлөн хөх, цэвэр цагаан олон өнгөний гайхалтай зохицлыг хадгалсан бөгөөд Венерагийн өөрийнх нь биеийн арьс нь өөр бусад ямар ч зүйлийг гоо сайхныг бүдгэрүүлэм санагдуулах ялдам өнгөөр зурсан байна. Бүсгүй сөхсийн хүсэл тачаал төрөм байрлалд, өөрт нь хэн ч зүрхлэн хэлж болохгүйг мэдэрсэн мэт юунаас ч үл айсан маягтай чөлөөтэй хэвтэж байгаагаар дүрсэлжээ. Энэ нь зүгээр нүцгэн биеийг харуулах гэсэн зураг биш юм. Цаана харагдаж буй толинд Венерагийн зөвхөн нүүр нь тусч байгаа бөгөөд уг зургийг дан бурхны үзлийг

агуулсан юм уу дан нүцгэн бие, садар самууныг дүрслэх гэсэн зураг хэмээн үзэж олт болохгүй. Уг зураг нь бүхэлдээ хүн төрөлхтний амьдралд байж болох гоо сайхны тухай ойлголтын нэгдмэл цогцыг харуулж буй бүтээл юм. Хэдийгээр хүний биеийн гоо сайхныг харуулахыг зорьсон, тэр дундаа гоо сайхны Венерагийн дүрийг асар олон зураач зурсан боловч уран бүтээлчид, олон нийт нэгэн дуугаар хүлээн зөвшөөрсөн гайхамшигтай бүтээл нь цөөн юм. Эдгээрийн нэгэнд Велазкезийн энэхүү "Тольдож буй Венера" зүй ёсоор орно. Уг зурган дээр XVIII зууны үеийн домгийн томоохон сэдэв болох "янагийн тэнгэр" Купидоныг бүхлээр нь тун тодорхой дүрслэн үзүүлжээ. Энэхүү зураг одоо Лондонгийн Үндэсний галерейд хадгалагдаж байна.

**"СИЛИКАТ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ**

"Силикат" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14.00 цагт тус компанийн хурлын танхимд болно.

**Хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн хэлбэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох, компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийг тогтоох зэрэг асуудлыг тус тус авч хэлэлцэн шийдвэрлэх

Бүртгэлийн өдөр: 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

Хувьцаа эзэмшигч та бүхэн 2015 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2015 оны 04 дүгээр сарын 10-ны хооронд Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон санал авах хуудастай "Силикат" ХК-ийн байранд ирж танилцана уу.

Харилцах утас: 99990095, 99053180  
E-mail хаяг: gere10321@yahoo.com  
**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

**EXPRESSION OF INTEREST**

A Vendor Conference in support of Khaan Quest 2015, a multi-national military exercise shall be held at The Corporate Hotel, Chinggis Avenue 9-2, Ulaanbaatar on Tuesday, 24 March 2015 from 10:00 am-1:00 p.m. All businesses interested in supporting the exercise (life support services, portable latrines, portable shower trailers, construction materials, heavy equipment, cell phone vendors, magazine and printing services) are encouraged to attend this conference. Any questions and/or concerns may be directed to Joshua.Pulver13@yahoo.com.

**ХАМТРАН АЖИЛЛАХ САНАЛ**

Khaan Quest 2015 ОУ-ын цэргийн сургуулилтад зориулан үйлчилгээ /байр, хоол, унаа, зөөврийн жорлон ба шуршүүр болон барилгын материал, хүнд тоног төхөөрөмж түрээслүүлэх, гар утасны үйлчилгээ, хэвлэлийн үйлчилгээ/ үзүүлэх сонирхолтой байгууллага, нэгжийг 2015 оны 3 сарын 24-ий Мянгар гаригийн 10:00-13:00 цагт болох уулзалтад урьж байна. Уулзалт Чингисийн Өргөн Чөлөөд байрлах Корпорет зочид буудлын уулзалтын танхимд болно. Холбогдох мэдээлэл болон сонирхсон асуултаа Joshua.Pulver13@yahoo.com хаягаар хандаж лавлана уу.